



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/35/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор А.Даваадорж
Утас: 261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор С.Алтанхуяг
Утас: 260512 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Ол дөш хайрхан аудит ХХК-ийн
Захирал А.Саранцэцэг
Утас: 99250679 Цахим хаяг: saraa_1303@yahoo.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
5.1 Шилэн дансны мэдээлэл	16
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Залруулсан алдаа	17
8.3 Албан шаардлага	18
8.4 Зөвлөмж.....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19-20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн бодлогын баримт бичиг
ҮЦТХТ ХХК	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧИНБАТ ТАНАА

2022.03.15 № 07/544
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлаар Эм Ти Си Сервис ХХК-тай охин компанийг үүсгэн байгуулсан байна. Компанийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээ, эдийн засгийн чадавх хангалтгүйгээс ажиллагсдын дундаж цалин хөлсийг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, ажлын багаж, хэрэгсэл, хувцас, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудад дээд шатны байгууллагууд нь анхаарал хандуулах шаардлагатай байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад дүгнэлт гаргаагүй болно.

Монголын Цахилгаан Холбоо ХК нь тайлант онд нийт 21,495.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 21,435.9 сая төгрөгийн зардал гарган, 5.6 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 17,990.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 17,951.0 сая төгрөгийн зардал гаргаж, 39.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллажээ.

Бусад асуудал

Монгол Улсад Коронавируст (КОВИД-19) цар тахлын халдварын тохиолдол бүртгэгдсэн өдрөөс эхэлж Төрийн холбоо, иргэн, хуулийн этгээдийн харилцаа холбооны тасралтгүй, техник, технологи, үйлчилгээний хэвийн ажиллагааг бүрэн ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 багц 68 зорилтын хүрээнд 158 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэгжүүлсэн 125, хэрэгжих шатандаа 11, хэрэгжээгүй 11, гүйцэтгэл 86 хувьтай гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,110,456,292.55	983,774,286.87
1.1.2	Дансны авлага	1,045,002,285.03	1,630,966,303.91
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	5,543,859.00	107,439,188.81
1.1.4	Бусад авлага	1,034,076,710.14	1,009,876,449.41
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,694,689,212.92	3,430,407,416.08
1.1.6	Бараа материал	2,726,488,382.60	2,701,204,154.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	514,748,390.68	1,703,703,940.89
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,131,005,132.92	11,567,371,740.63
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,285,401,604.15	22,204,400,547.93
1.2.2	Биет бус хөрөнгө	9,211,956,253.96	9,094,952,882.00
1.2.3	Биологийн хөрөнгө	4,600,000.00	3,930,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	121,670,922.96	123,595,964.48
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,623,628,781.07	31,426,879,394.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	41,754,633,913.99	42,994,251,135.04
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	422,307,603.76	1,918,108,748.73
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	25,314,271.24	61,915,585.50
2.1.1.4	НДШ-ийн өглөг	56,700.88	2,622,268.38
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	146,379,171.50	146,379,171.50
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	638,040,324.66	664,637,573.56
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,638,183,216.37	1,337,290,743.45
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,870,281,288.41	4,130,954,091.12
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,241,131,041.61	8,501,803,844.32
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	- хувийн	137,098,889.00	137,098,889.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	999,486,536.10	999,486,536.10
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	22,679,718,574.89	22,658,662,993.23
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	34,513,502,872.38	34,492,447,290.72
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	41,754,633,913.99	42,994,251,135.04

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	17,631,266,881.30	16,358,460,979.52
2	Борлуулалтын өртөг	(14,340,980,751.68)	(13,523,394,712.77)
3	Нийт ашиг (алдагдал)	3,290,286,129.62	2,835,066,266.75
4	Түрээсийн орлого	853,775,988.38	775,900,262.47
5	Хүүний орлого	454,074,760.29	282,705,625.45
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	190,551,553.06	572,705,901.95
9	Борлуулалт, маркетингийн зардал	(1,443,132,242.28)	(1,256,556,797.18)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(2,828,822,561.01)	(2,544,492,166.98)
11	Санхүүгийн зардал	(54,141,889.25)	(48,206,818.19)
12	Бусад зардал	(485,688,439.30)	(577,883,716.05)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	24,591,160.32	(116,069.43)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	90,536,006.30	0.00
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	92,030,466.13	39,122,488.79
19	Орлогын татварын зардал	(48,641,674.89)	(34,407,370.05)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	43,388,791.24	4,715,118.74
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	43,388,791.24	4,715,118.74
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	43,388,791.24	4,715,118.74
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	43,388,791.24	4,715,118.74

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589	999,486,536.10	8,247,270,172.39	22,764,326,641.50	34,598,110,938.99
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(102,126,581.85)	(102,126,581.85)
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	43,388,791.24	43,388,791.24
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00		0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт		0.00		0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(25,870,276.00)	(25,870,276.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00		0.00	0.00	0.00
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,679,718,574.89	34,513,502,872.38
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	4,715,118.74	4,715,118.74
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00		0.00	
14	Өмчид гарсан өөрчлөлт		0.00		0.00	
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(25,770,700.40)	(25,770,700.40)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00		0.00	0.00	
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,658,662,993.23	34,492,447,290.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн(+)	21,974,056,611.15	18,608,925,278.22
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,985,099,656.84	16,622,130,308.69
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	29,586,826.00	0.00
	Бусад мөнгөн орлого	2,959,370,128.31	1,986,794,969.53
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(18,850,910,142.67)	(16,930,576,125.15)
	Ажиллагчдад төлсөн	(5,384,339,963.60)	(5,313,320,597.97)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,599,706,575.90)	(1,641,485,648.74)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(1,844,899,064.98)	(1,811,903,780.69)
	Ашиглалтын зардалд төлсөн	(5,693,803,410.76)	(4,509,381,009.75)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(292,271,126.99)	(261,557,451.20)
	Татварын байгууллагад төлсөн	(1,876,808,205.14)	(1,602,526,082.61)
	Даатгалын төлбөрт төлсөн	(15,696,808.00)	(1,539,900.00)
	Бусад мөнгөн зарлага	(2,143,384,987.30)	(1,788,861,654.19)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,123,146,468.48	1,678,349,153.07
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн(+)	1,125,178,800.70	417,578,147.18
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	41,590,368.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	6,681,338.00	3,552,937.00
	Хүлээн авсан хүүний орлого	408,206,755.81	395,886,940.49
	Хүлээн авсан ноогдол ашиг		
	Бусад орлого.	668,700,338.89	18,138,269.69
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(4,112,962,056.22)	(2,196,835,479.88)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,350,676,707.99)	(1,696,218,437.23)
	Бусад зарлага.	(1,762,285,348.23)	(500,617,042.65)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,987,783,255.52)	(1,779,257,332.70)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн(+)	15,752,122.43	5,910.20
	Валютын зөрүүний орлого	15,752,122.43	5,910.20
3.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(27,330,705.91)	(25,779,736.25)
	Төлсөн ногдол ашиг	(26,268,128.30)	(25,770,700.40)
	Валютын зөрүүний алдагдал	(1,062,577.61)	(9,035.85)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,578,583.48)	(25,773,826.05)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	123,784,629.48	(126,682,005.68)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	986,671,663.07	1,110,456,292.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,110,456,292.55	983,774,286.87

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэм нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
A	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	1	2	3	4	5	6
1	Олон улсын яриа	мин	211,434	355,000	209,926	(145,074)	59.1
2	Суурин утас орох яриа	мин	47,958,236	59,947,795	46,436,413	(13,511,382)	77.5
3	Суурин утас гарах яриа	мин	36,051,897	40,558,384	35,476,349	(5,082,035)	87.5
4	Зууны лавлах	мин	219,032	250,000	178,468	(71,532)	71.4
5	Бусад лавлах	мин	233,423	287,000	227,209	(59,791)	79.2
6	Суурин утас	Хэр/тоо	52,373	57,202	55,897	(1,305)	97.7
7	Интернэт	Хэр/тоо	18,649	23,022	16,428	(6,594)	71.4
8	КаТВ	Хэр/тоо	16,655	19,497	17,815	(1,682)	91.4
B	Үйл ажиллагааны орлого	Сая/төг	19,246.8	21,495.0	17,990.2	(3,505)	83.7
1	Борлуулалтын орлого /цэвэр/	Сая/төг	17,631.3	20,256.1	16,358.4	(3,898)	80.8
2	Түрээсийн орлого	Сая/төг	853.8	970.2	775.9	(194)	80.0
3	Хүүгийн орлого	Сая/төг	454.1	201.7	282.7	81	140.2
4	Бусад орлого	Сая/төг	190.6	42.0	572.7	531	1363.6
5	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	Сая/төг	26.5	25.0	0.5	(24)	2.0
6	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	Сая/төг	90.5	-	-	-	0.0
B	Үйл ажиллагааны зардал	Сая/төг	19,154.8	21,435.9	17,951.0	(3,485)	83.7
1	Борлуулалтын өртөг	Сая/төг	14,341.3	16,750.9	13,523.4	(3,227)	80.7
2	Ерөнхий ба удирдлагын зардал	Сая/төг	2,828.8	2,679.6	2,544.5	(135)	95.0
3	Борлуулалт удирдлагын зардал	Сая/төг	1,443.1	1,370.9	1,256.6	(114)	91.7
4	Санхүүгийн болон бусад зардал	Сая/төг	541.6	634.5	626.5	(8)	98.7
B	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	Сая/төг	92.0	59.1	39.1	(20)	66.2
	Орлогын татварын зардал	Сая/төг	48.6	53.5	34.4	(19)	64.3
	Татварын дараах ашиг (алдагдал)	Сая/төг	43.4	5.6	4.7	(1)	83.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийг үр ашигтай зарцуулж, зардлыг хэмнэх бодлого чиглэлийг баримтлах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, борлуулалтын орлогын болон ашгийн төлөвлөгөөг биелүүлж байх, мал амьтадыг зах зээлийн үнээр үнэлэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 12-ны хооронд Ол дөш хайрхан аудит ХХК-ийн ахлах аудитор П.Сэрсмаа, аудитор Ц.Бумцэнд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, захирал А.Саранцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1а/74 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө нийт 33 ажил хийхээр төлөвлөснөөс 29 ажлыг 100 хувь, 1 ажил нь 50 хувь, 3 ажил ковидоос шалтгаалан хийгдээгүй байна. Дотоод аудитын газрын төлөвлөгөөний гүйцэтгэл 87.8 хувийн биелэлтэй байна. Мөн орон нутгийн холбооны газруудад 11 акт буюу 13.4 сая төгрөгийн төлбөрийн акт тавьж бүрэн барагдуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 41,754.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 417.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн зорилго нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн өргөн сонголт бүхий үйлчилгээ, орон нутаг, улс, хот хоорондын цахилгаан холбооны ашиглалт үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт интернэтийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. 2021 онд шинээр хийгдсэн ажлуудаас дурдвал:

- Улаанбаатар хотын Гүнт, Санзай, Горхи –Тэрэлж, Багахангай, Хонхор зэрэг хүн ам нягтаршсан алслагдсан суурьшлын бүс, орон нутагт 20 аймгийн төв, нэг суманд шилэн кабелийн өргөтгөлийн FTTH сүлжээг байгуулах төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн;
- Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-тай амжилттай хийсэн хэлэлцээрийн үр дүнд 1М урсгалын өртгийг бууруулж, урсгалын нийт багтаамжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулсан;
- Бодит хурдны хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын үр дүнд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Ашигт малтмал газрын тосны газар, Барилга хот байгуулалтын яам, Сонжин групп ХХК, Ёкозунанэт ХХК, Бөртө төрийн өмчит үйлчилгээний газар, Чингис хаан музей зэрэг байгууллагыг шинээр холбосон;
- Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хөрөнгө оруулалтын зардал гаргалгүйгээр байгууллагын Call center үйлчилгээг шинээр нэвтрүүлээд байна.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар баталсан дүрэмд *“Компани нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, нийгэм эдийн засгийн үүрэг хариуцлагыг дараах байдлаар хүлээнэ”* Үүнд:

- Иргэн, Засгийн газрын болон бусад хэрэглэгчдэд өндөр чанартай, харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээг үзүүлэх;
- Ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах хувьцаа эзэмшигчдэдээ үр өгөөжтэй байх;
- Компани нь харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлнэ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутаг, улс, хот хоорондын цахилгаан холбооны ашиглалт, үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт интернэтийн үйлчилгээ эрхлэх статустай байна. Өмчийн 94.7 хувийг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувийг 3952 хувьцаа эзэмшигч тус тус эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголын Цахилгаан Холбоо ХК нь анх 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” нэрээр байгуулагдаж, Засгийн газрын “Өмч хувьчлалын комисс”-ын 1995

оны 28 дугаар тогтоолыг үндэслэн “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийг байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 2.4, 76.1.8, 76.1.9 дэх заалт, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.2 дахь заалттай нийцэж байна.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.6 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг Олон Улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд хяналт шалгалт дүн шинжилгээний албыг дотоод аудитын газар болгон өргөтгөж, үүн дотроо чанарын хяналтын албыг байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2020 онд нийт 49 нэгж, 764 орон тоотой үйл ажиллагаа явуулж байсныг өөрчилж, 2021 онд чиг үүргийн давхардлыг арилгаж 46 нэгж, 720 орон тоон дээр 708 ажилтан ажиллаж байна. Тухайлбал Компанийн удирдлагын хувьд 4 дэд захирлын орон тоог нягтруулан 3 орон тоотой болгон удирдлагын болон Улаанбаатар хотын газар, албаны хэмжээнд албан тушаалын давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, алдагдалтай ажиллаж байгаа сумдын ажилтнуудын сул орон тоог арилгаж, нийт ажилтнуудын үндсэн цалинг 2019 оноос хойш нэмэгдүүлэлгүйгээр өмнөх оны түвшинд тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол “Ковид-19 цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- НБББББ-т дансны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын А/25 тоот тушаалаар Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын дагуу шинэчлэн боловсруулж нэмэлтээр оруулсан;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,110,456.3	983,774.3	(126,682.0)
БХХО	3,694,689.2	3,430,407.4	(264,281.8)
Авлага	2,084,622.8	2,748,281.9	663,659.1
Урьдчилгаа	514,748.4	1,703,703.9	1,188,955.6
Бараа материал	2,726,488.4	2,701,204.2	(25,284.2)
Үндсэн хөрөнгө	22,285,401.6	22,204,400.5	(81,001.1)
Биет бус хөрөнгө	9,211,956.3	9,094,952.9	(117,003.4)
Биологийн хөрөнгө	4,600.0	3,930.0	(670.0)
Хойшлогдсон татварын хөрөнгө	121,670.9	123,596.0	1,925.0
Нийт хөрөнгийн дүн	41,754,633.9	42,994,251.1	1,239,617.2
Дансны өглөг	447,678.6	1,982,646.6	1,534,968.0
Богино хугацаат өглөг	1,638,183.2	1,337,290.7	(300,892.5)
Ноогдол ашгийн өглөг	146,379.2	146,379.2	-
Урьдчилж орсон орлого	638,040.3	664,637.6	26,597.2
Урт хугацаат өглөг	4,370,849.8	4,370,849.8	-
Эздийн өмч	34,513,502.9	34,492,447.3	(21,055.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	41,754,633.9	42,994,251.1	1,239,617.2

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 1.2 сая төгрөг, жижиг мөнгөн сангийн 13.7 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 951.5 сая төгрөг, замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.3 сая төгрөг, Эм Ти Си сервис ХХК (охин компани)-ийн харилцах дансны үлдэгдэл 17.3 сая төгрөг, нийт 983.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст авлага данс 4,451.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 210.3 сая төгрөгийн үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна. Өмнөх оноос авлага 663.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Цар тахлын нөхцөлөөс шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож хөл хорионд орсон, эдийн засгийн байдал нь хүндэрснээс компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгчийн харилцан холболтын тусгай дугаарын авлага өссөн, хэрэглэгчийн суурин утас болон интернэтийн үйлчилгээний бартерын гэрээгээр үйлчилгээ үзүүлээд тайлант хугацаанд харилцагчаас үйлчилгээгээ аваагүй зэрэгтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд ААНОАТ-ын авлага 12.7 сая төгрөг, НӨАТ-ын авлага 83.9 сая төгрөг, НДШ-ийн авлага 10.5 сая төгрөгийг эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 110.4 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 2,637.8 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг шууд аргаар тооцдог байна.

Тайлант онд 8 ажлын төлбөрт 2,042.4 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 853.5 сая төгрөгийн 6 ажлын гүйцэтгэлийг хүлээн авч тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,701.2 сая төгрөг болж 25.3 сая төгрөгөөр буурсан.

Тайлант онд худалдан авалтаар 4,032.0 сая төгрөг, Японы KDDI компаниас үнэ төлбөргүй хүлээн авсан 504.1 сая төгрөгийн нийт 4,536.1 сая төгрөгөөр бараа материал данс нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй, технологийн хоцрогдолд орсон 223.1 сая төгрөгийн бараа материалын асуудлыг шийдвэрлэхээр завсрын аудитаар зөвлөмж өгснийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, заримыг худалдан борлуулсан, зарим хэсэг буюу дотоодод хэрэглэхээ больсон картыг гадаад ярианы карт болгон ашиглахаар бэлтгэж байна. Оны эцсийн 2,701.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл нь өмнөх онуудын үлдэгдэл байна. Үүнд: ОТТ үйлчилгээний үндсэн дамжуулалтын төхөөрөмж болох transceiver, encoder төхөөрөмжүүд нь сигналын дамжуулалтын алдаа өгч дүрсний гажуудал үүссэн тул илүү хүчин чадал сайтай төхөөрөмжүүдээр солих шаардлагатай болсон. БНХАУ хил гааль хаасантай холбогдуулан бэлтгэн нийлүүлэлт удааширсан. 2021 оны 12 сараас 878.2 сая төгрөгийн дээрх төхөөрөмжийг өөрсдийн ажилчдын хүчээр шинэчлэн сайжруулж, ажиллагааг хэвийн болгож, 2022 оны 1 сараас үйлчилгээг өргөтгөх шинэ хэрэглэгч холбох ажлыг эхлүүлээд байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Шинээр 2,688.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тайлант онд 2,769.3 сая төгрөгийн элэгдэл байгуулж, жилийн эцэст үндсэн хөрөнгө 81.0 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 70.5 хувь нь хуримтлагдсан элэгдэл тооцогдон цэвэр хөрөнгийн хэмжээ 22,204.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Биет бус хөрөнгө 4.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 121.5 сая төгрөгөөр элэгдэл байгуулснаас 117.0 сая төгрөгөөр буурсан байна. Биет бус хөрөнгийг актлуулахаар сүүлийн 5 жилд санал оруулаагүйгээс элэгдлийн норм хугацаа дууссан 2,561.0 сая төгрөгийн биет бус хөрөнгө байна.

Тайлант онд Эм Ти Си Сервис ХХК охин компанид оруулсан хөрөнгө оруулалт урт хугацаат хөрөнгө оруулалт 165.2 сая төгрөг бүртгэгдсэн.

Богино хугацаат өр төлбөр данс 4,130.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 136.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна.

Өмнөх оноос өр төлбөр 1,260.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Мэдээлэл холбооны сүлжээ багц гэрээний төлбөр, харилцан холболтын тооцоо, НӨАТ-ын тооцоо, тусгай дугаар тооцоо, гадаад тооцоо нь тайлант онд бүртгэгдэж дараа онд төлдөг, Нэгтгэсэн тайланд охин компанийн НӨАТ-ын өглөг, дараа тооцоогоор гэрээ байгуулсан борлуулах барааны өглөг, Зохицуулах хорооны лицензийн өглөг өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 12 жил болсон 4,370.8 сая төгрөгийн үлдэгдэл байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 08 дугаар сарын 02-ны өдөр 186 дугаар тогтоолоор холбооны үндсэн суурь сүлжээний төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэж, Төрийн өмчийн хороо 2006 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 491 дугаар тогтоолоор “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит ХХК-ийг байгуулан бүтцийн өөрчлөлт хийж “Монголын цахилгаан холбоо” ХК-ийг Монголын цахилгаан холбоо ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК болгон хоёр хуваах үед үүссэн өр байна.

Шалгуулагч байгууллага Чингис хаан банкттай 2019 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 5101003153 дугаартай харилцах дансны үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний хавсралтаар тусгай нөхцөлтэй харилцах дансны нөхцөлийг харилцан тохиролцож, жилийн 12.4 хувийн хүүтэйгээр 500.0 сая төгрөгийг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хүртэл хадгалуулж, нийт 34.8 сая төгрөгийн хүү тооцож авсан байна. Чингис хаан банкны харилцах дансыг 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хаажээ.

Шалгагдагч байгууллагын НББББ-т зардлыг чиг үүргийн аргаар ангилж, өртгийн төвүүдээр хуваарилан орлого, зардал зохицох зарчмаар хүлээн зөвшөөрч, аккрузал суурьт үндэслэн өртгөөр нь үнэлэн тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, Борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, Лицензийн зардал, гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-ээр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 167 дугаар хурлын 2 дугаар тогтоолоор компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 20,700.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 20,586.4 сая төгрөгөөр, 38.2 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,757.8 сая төгрөгийг төлөвлөж баталсан байна. Энэхүү батлагдсан төлөвлөгөөг ТУЗ-ийн 2021 оны 171 дугаар хурлын 1 тогтоолоор компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, нийт орлогыг 21,495.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 21,435.9 сая төгрөгөөр, 5.6 сая төгрөгийн ашигтай байхаар тодотгосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,095.5 сая төгрөгийг баталсан байна.

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Б	Үйл ажиллагааны орлого	Сая/төг	19,246.8	21,495.0	17,990.2	(3,504.8)	83.7
1	Борлуулалтын орлого /цэвэр/	Сая/төг	17,631.3	20,256.1	16,358.4	(3,897.7)	80.8
2	Түрээсийн орлого	Сая/төг	853.8	970.2	775.9	(194.3)	79.9
3	Хүүгийн орлого	Сая/төг	454.1	201.7	282.7	81	140.2
4	Бусад орлого	Сая/төг	190.6	42.0	572.7	530.7	1363.6
5	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	Сая/төг	26.5	25.0	0.5	(24)	2.0
6	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	Сая/төг	90.5	-	-	-	-
Б	Үйл ажиллагааны зардал	Сая/төг	19,154.8	21,435.9	17,951.0	(3,484.9)	83.7
1	Борлуулалтын өртөг	Сая/төг	14,341.3	16,750.9	13,523.4	(3,227.5)	80.7
2	Ерөнхий ба удирдлагын зардал	Сая/төг	2,828.8	2,679.6	2,544.5	(135.1)	94.9
3	Борлуулалт удирдлагын зардал	Сая/төг	1,443.1	1,370.9	1,256.6	(114.3)	91.7
4	Санхүүгийн болон бусад зардал	Сая/төг	541.6	634.5	626.5	(8.0)	98.7
В	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	Сая/төг	92.0	59.1	39.1	(20.0)	66.2
	Орлогын татварын зардал	Сая/төг	48.6	53.5	34.4	(19.1)	64.3
	Татварын дараах ашиг (алдагдал)	Сая/төг	43.4	5.6	4.7	(1)	83.9

Нийт орлогын гүйцэтгэл 17,990.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 3,504.8 сая төгрөг буюу 16 хувиар тасарсан нь суурин утас, интернэт, багцын суурь хураамж орлого 2,346.6 сая төгрөгөөр, TV Room үйлчилгээ 160.9 сая төгрөгөөр, борлуулсан бараа 997.3 сая төгрөгөөр тус тус тасарсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 17,951.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,484.9 сая төгрөг буюу 16 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Үндсэн үйл ажиллагааны өртөг 2,126.0 төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 1,358.9 төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн. Үйл ажиллагааны өртөг буурахад интернэтийн хэрэглээ нэмэгдэнэ гэж төлөвлөсөн боловч үндсэн сүлжээний өргөтгөл, мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны урсгалаас хамаарч хэрэглээний ачаалал өсөөгүй тул 874.8 сая төгрөгөөр суваг, сүлжээний түрээс буурсан, мөн ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн төхөөрөмж 3000 ш борлуулахаар төлөвлөсөн ч ОТТ үйлчилгээний техникийн зүгшрүүлэлтээс хамааран борлуулаагүй тул борлуулсан бүтээгдэхүүний өртөг 991.2 сая төгрөгөөр, ярианы ачаалал буурснаас харилцан холболтын зардал 50.0 сая төгрөг, ОТТ үйлчилгээний техникийн зүгшрүүлэлтээс хамааран контентын зардал 210.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

Засгийн газрын 2021 оны 43 тоот тогтоол, ТӨБЗГ-аас өгсөн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А-1/66 тоот албан даалгаврын дагуу бүх нэр төрлийн зардалд хэмнэлтийн горимоор ажилласан нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 9 ажилд өөрийн эх үүсвэрээс 1,129.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, гүйцэтгүүлэн хүлээн авсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 4.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 0.9 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 166 дугаар хурлын 01 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 2020 оны цэвэр ашгаас 25.8 сая төгрөгийн ногдол ашиг буюу нэгж хувьцаанд 1 төгрөгийн ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилснаас төрийн өмчид ногдох 24.5 сая төгрөгийг төрийн сангийн ТӨБЗГ-ын дансанд шилжүүлэн, үлдсэн 5.3 хувьд ногдох 1.3 сая төгрөгийн ногдол ашгийг ҮЦТХТ ХХК-иар дамжуулан олгосон байна.

ТӨБЗГ-ын даргын 2018 оны А-1/920 тоот албан бичгийн дагуу түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэхгүй болсон байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим системд 6 нэр төрлийн мэдээллийг жил, сар бүрийн давтамжтайгаар 6,095.5 сая төгрөгийг 62 мэдээллийг, байршуулахаас 59 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэснийг зөрчиж 6 нэр төрлийн 12.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Мөн тогтоолыг зөрчиж бэлэг дурсгалд 4.5 сая, түүхэн замнал дурсамжийн ном хэвлүүлэхэд 1.2 сая төгрөг нийт 5.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хөрөнгийг үр ашигтай зарцуулж, зардлыг хэмнэж, ажиллах бодлого чиглэлийг баримтлан ажиллах зөвлөмж өгөх.

6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 396.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 169.1 сая төгрөгийг залруулж, 223.1 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 3.9 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 253.7 сая төгрөгийн зөрчил, 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөг/						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага							
Зөвлөмж	3	253.7	1		2	253.7	66.7
Нийт дүн	3	253.7	1		2	253.7	66.7

Өмнөх оны аудитаар 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага өглөө.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ашиглагдаагүй үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнөөс гадуур урсгал зардлаас үндсэн хөрөнгө, бараа материалыг шууд худалдан авалтаар бэлтгэсэн зэргийг дараагийн аудитаар авч үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,826.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,475.3 сая төгрөгийн алдааг залруулж, 347.2 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 351.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,475.3 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулгыг 4,483.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн дүнг 992.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

8.3 Албан шаардлага

1. Тайлант оны эцэст 210.3 сая төгрөгийн авлагыг, 136.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн санхүүгийн тайлангийн санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, эрх үүрэг, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон борлуулалтын орлогын төлөвлөгөөг 3,504.8 сая төгрөг буюу 16 хувиар, татвар төлөхийн өмнөх ашиг 20.0 сая буюу 36 хувиар, ашгийн төлөвлөгөөг 0.9 сая төгрөг буюу 16 хувиар тус тус биелүүлээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 83.1"Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна" 95.1 "Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна", 95.4" Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна" 96.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 90 дүгээр тушаалын холбогдох заалт зэрэгтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, борлуулалтын орлогын болон ашгийн төлөвлөгөөг биелүүлж байх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Биологийн хөрөнгө 3.9 сая төгрөгийн 69 мал амьтадын нэг бүрийг зах зээлийн үнээр үнэлж, бүртгээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх үүрэг, тохиолдсон байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Мал амьтадыг зах зээлийн үнээр бүртгэж санхүүгийн тайланд тусгах зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	МЦХ-ХК	АХГ-2022/35-НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн тодруулгад үндсэн хөрөнгийг зөрүүтэй тусгасан байна.	Үндсэн хөрөнгийн тодруулгад залруулга хийх	1	4,483,275.8	1	4,483,275.8						
2	МЦХ-ХК	АХГ-2022/35-НА-СТА-ТӨА	Мөнгөн гүйлгээний тайлангийн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн дүнг дутуу тайлагнасан байна	Мөнгөн гүйлгээний тайланд залруулга хийх	1	992,052.2	1	992,052.2						
3	МЦХ-ХК	АХГ-2022/35-НА-СТА-ТӨА	Авлагын 210,300.5 мянган төгрөгийн үлдэгдэл, өглөгийн 136,900.0 мянган төгрөгийн үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна.	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй	1	347,200.5					1	347,200.5		
4	МЦХ-ХК	АХГ-2022/35-НА-СТА-ТӨА	Биологийн хөрөнгө 3,930.0 мянган төгрөгийн 69 мал амьтадын нэг бүрийн үнийг зах зээлийн үнээр бүртгээгүй.	Малыг зах зээлийн үнээр бүртгэх	1	3,930.0							1	3,930.0
5	МЦХ-ХК	АХГ-2022/35-НА	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн	1						1			

			биелүүлээгүй.	төлөвлөгөөг ханган биелүүлэх зөвлөмж өгөх										
ДҮН					5	5,826,458.5	2	5,475,328.0			2	347,200.5	1	3,930.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
1	МЦХ-ХК	АХГ-2022/35/-НА-СТА-ТӨА	ЗГ-ын 13 тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчиж албан конторын тавилга бэлтгэсэн (14 нэр төрлийн хөрөнгө) 12,926.5 мянган төгрөг, бэлэг дурсгалд 4,525.0 мянган төгрөг, түүхэн замнал дурсамжийн ном хэвлүүлэхэд 1,200.0 мянган төгрөг зарцуулсан байна.	Засгийн газрын 2021 оны 43 тогтоол зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	18,651.5							1	18,651.5
2	МЦХ-ХК	АХГ-2022/35/-НА-СТА-ТӨА	Шилэн дансны тухай хуулийг зөрчиж, 3 мэдээллийг хугацаанд байршуулаагүй	Шилэн дансны тухай хуулийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж	1								1	
ДҮН					2	18,651.5							2	18,651.5
НИЙТ ДҮН					7	5,845,110.0	2	5,475,328.0			3	347,200.5	3	22,581.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 362/А0150054

Улаанбаатар хот

АХГ 2022/35/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 210,300,504.00 төгрөгийн авлага, 136,900,000.00 төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр төлбөрийг актаар баталгаажуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чинбат, санхүү бүртгэл, аж ахуйн газрын дарга Ж.Баасандорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ОЛ ДӨШ ХАЙРХАН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
П.СЭРСМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-31.Docx

0010801035



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 365/АО/50054

Улаанбаатар хот

АХГ-2022/35/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Эдийн засгийн зорилтот түвшингийн борлуулалтын орлогын төлөвлөгөөг 3,504,867,200.00 төгрөг буюу 16 хувиар, татвар төлөхийн өмнөх ашиг 19,998,200.00 төгрөг буюу 36 хувиар, ашгийн төлөвлөгөөг 905,700.00 төгрөг буюу 16 хувиар тус тус биелүүлээгүй байна.


Энэ нь Компанийн тухай хуулийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна." Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чинбат, Санхүү бүртгэл, аж ахуйн газрын дарга Ж. Баасандорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ОЛ ДӨШ ХАЙРХАН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

П.СЭРСМАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-267230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar-40.Docx

0010801053

